



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
НЭР ДЭВШИГЧ ТАНАА

Монгол Улсын Их Хурлын
СОНГУУЛЬ
2024

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ | 4 |
| 1.1. Нам, эвслээс нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг | 4 |
| 1.2. Бие даан нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг | 7 |
| ХОЁР. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ЦАХИМ СИСТЕМД ҮҮСГЭХ, МЭДҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ | 10 |
| ГУРАВ. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА | 24 |
| ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ, ТҮҮНИЙГ ТАЙЛАГНАХ | 30 |
| 4.1. Сонгуулийн зардал | 30 |
| 4.2. Сонгуулийн зардлыг тайлагнах | 33 |
| ТАВ. СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ЦАХИМ СИСТЕМЭЭР НЭР ДЭВШИГЧ БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР | 36 |
| 5.1. Нам, эвслээс нэр дэвшигч цахимаар бүртгүүлэх | 37 |
| 5.2. Бие даан нэр дэвшигч цахимаар бүртгүүлэх | 45 |
| 5.2.1. Бие даан нэр дэвшигч 801 гарын үсэг цуглуулах заавар | 46 |



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

1.1. НАМ, ЭВСЛЭЭС НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Нам, эвслээс нэр дэвшигчийн баримт бичгийг дор дурдсан дарааллын дагуу нэр дэвшигч тус бүрээр бүрдүүлэн 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Дараах лавлагаа, бүрдүүлэх баримт бичгийг E-mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системийн “Сонгууль” - “Улсын Их Хурлын сонгууль” үйлчилгээгээр орж www.e-election.mn системээр дамжуулан авах боломжтой.

/Уг үйлчилгээтэй холбоотой асуудлаар Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшигчийн бүртгэл хариуцсан албан хаагчдын 9900-7904, 9922-2507 утсаар мэдээлэл авна уу./

1. Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, сонгуулийн тойрогт нэр дэвшигчидийн жагсаалт болон жагсаалтаар нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчидийн нэрийн жагсаалт:

- 1.1. Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр;
- 1.2. Сонгуулийн тойрогт нэр дэвшигчидийн жагсаалт болон жагсаалтаар нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчидийн нэрийн жагсаалт

/Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Маягтыг www.m-election.mn цахим хуудасны Монгол Улсын Их Хурлын сонгууль-2024 цэсний Журам, заавар, маягт хэсгээс авах боломжтой/;

Линк: <https://m-election.mn/sub/cG9zdDo1NDA5>

2. Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл

/Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт. Маягтыг www.m-election.mn цахим хуудасны Монгол Улсын Их Хурлын сонгууль-2024 цэсний Журам, заавар, маягт хэсгээс авах эсхүл www.e-election.mn цахим системд бүртгүүлэх боломжтой/; Линк: <https://m-election.mn/sub/cG9zdDo1NDA5>

3. Төрийн жинхэнэ албан хаагч, Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, Төрийн болон орон нутгийн өмчйт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар;



4. Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаарх Улсын Дээд шүүхийн лавлагаа авахад:

-Лавлагааг 2024.04.22-ны өдрөөс эхлэн Улсын Дээд шүүхээс авна.

Лавлагаа авахдаа Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга, МҮХАҮТДэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/19 дүгээр хамтарсан тушаалаар баталсан дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

1. Иргэний үнэмлэхний хуулбар
2. Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус, нөхөн /аль тохирохыг доогуур зурах/ сонгуулийн дугаар тойрогт нэр дэвшигчийн лавлагаа хүссэн өргөдөл. /Загвар-1/
3. Банк, бусад хуулийн этгээд иргэнд төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хуульд заасны дагуу шүүх, арбитрт хариуцагчаар оролцож байсан эсэх мэдээлэл. /Загвар-2,3/

Лавлагаа авахтай холбоотой мэдээллийг Монгол Улсын Дээд шүүхийн www.supremecourt.mn цахим хуудас, Мэдээлэл лавлагааны ажилтан 51-261698 дугаараас лавлана уу.

5. Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;

5.1. Нэр дэвшигч <https://etax.mta.mn/> цахим хуудаст хандаж татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг авна.

Иргэн, хуулийн этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлснээр Цахим татварын системийн хэрэглэгч болж, татварын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болно.

Иймд иргэн <https://etax.mta.mn/> цахим хуудаст хандан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

/Бүртгүүлэх зааврыг Татварын ерөнхий газрын <https://etax.mta.mn/> цахим хуудаснаас авах боломжтой./

5.2 Нэр дэвшигч аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол <https://etax.mta.mn/> цахим хуудаст хандаж байгууллагын татварын тодорхойлолтыг авна.

Тодорхойлолтыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан /захирал, нягтлан бодогч/, эсхүл нэр дэвшигч өөрөө цахим татварын системээс авна.

/Тодорхойлолт авах дэлгэрэнгүй зааврыг Татварын ерөнхий газрын <https://etax.mta.mn/> цахим хуудаснаас авна уу./



Лавлагаатай холбоотой асуудлаар 1800-1288 дугаар утсаар болон Татварын ерөнхий газрын татвар төлөгчид үйлчлэх газрын бүртгэлийн хэлтсийн татварын улсын байцаагч Д.Жамсранжав /90092699/, Эрсдлийн удирдлагын газрын судалгаа шинжилгээний хэлтсийн татварын улсын байцаагч Д.Оюундэлгэр /99188346/ нараас мэдээлэл авах боломжтой.

6. Нэр дэвшигчийн намтар

/Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. Маягтыг www.m-election.mn цахим хуудасны Монгол Улсын Их Хурлын сонгууль-2024 цэсний Журам, заавар, маягт хэсгээсавах эсхүл www.e-election.mn цахим системд бүртгүүлэх боломжтой/;

Линк: <https://m-election.mn/sub/cG9zdDo1NDA5>

7. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар

-Төрийн үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn цахим системээс авч болно.

8. Ял эдэлж байгаа эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.

Иргэний ял эдэлж байгаа эсэх буюу “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх” тухай лавлагааг Засаг даргын тамгын газрын дэргэдэх төрийн үйлчилгээний нэг цэг, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд болон төрийн нэгдсэн www.e-mongolia.mn системээс авах эсхүл Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгж /Баянзүрх дүүгийн 2 дугаар хороо “Цагдаагийн хотхон” Цагдаагийн төв архивын байр Лавлагааны сан/- эс авах боломжтой. /Лавлагааны сангийн 70191060, 70191089 дугаар утсаар лавлах/

9. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагaa

Лавлагаа авах талаарх хүсэлтийг тухайн нэр дэвшиж байгаа сонгуулийн тойрог болон өөрийн оршин суугаа газрынхаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бичгээр гаргаж, албан бичгээр лавлагааг авна.

/Лавлагаа нь ажлын 2 өдөрт гарах бөгөөд ЦЕГ-ын Лавлагааны сангийн 70191060, 70191089 дугаар утсаар лавландаа уу. Лавлагааг 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн авна/

10. Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг

Нэр дэвшигч хөрөнгө, орлогын мэдүүлгээ 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 23-ны өдрийн дотор Авлигатай тэмцэх газрын <https://meduulegiaac.mn/> цахим хуудсаар дамжуулан мэдүүлнэ.

/Нэр дэвшигчийн ХОМ бөглөх дэлгэрэнгүй заавартай танилцана уу/

— о О о —



ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ЦАХИМ СИСТЕМДҮҮСГЭХ, МЭДҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ


НЭР ДЭВШИГЧИЙН АНХААРАЛД

- Нэр дэвшигч нь 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “ХОМ” гэх/ мэдүүлэхийн тулд Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн А08/A31 дугаар хамтарсан захирамж/ тушаалын хавсралтаар батлагдсан “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ <https://meduuleg.iaac.mn/>-д БҮРТГҮҮЛЭХ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН БҮРТГЭЛ, ЛАВЛАГААНЫ МЯГТ”-ыг бүрэн гүйцэд бөглөж 2024 оын 5 дугаар сарын 21-ний дотор burtgel@gec.gov.mn цахим хаягт илгээсэн байх шаардлагатай. Уг мэдээллийг хүргүүлснээр таны и-мэйл хаягт <https://meduuleg.iaac.mn/> цахим системд нэвтрэх нууц үг илгээгдэнэ. Та өөрийн байнга ашигладаг и-мэйл хаягаа бүрэн, зөв бичих шаардлагатайг анхаарна уу. **Хэрэв нэр дэвшигч нь Авлигын эсрэг хуульд заасны дагуу 2023 оны ХОМ-ийг АТГ-ын <https://meduuleg.iaac.mn/> системд 2024 онд гаргасан бол УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн ХОМ гаргах шаардлагагүй.**
- Нэр дэвшигчийн ХОМ-т 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өөрийн болон гэр булийн гишүүдийн орлого, эзэмшил, өмчлөлийн хөрөнгийг мэдүүлнэ.
- Өөрийн болон гэр булийн гишүүдийн хөрөнгө, орлогыг үнэн зөв мэдүүлэх ба мэдүүлгийн “Тайлбар” хэсэгт тухайн хөрөнгө, орлогын эх үүсвэрийг дэлгэрэнгүй бичнэ.
- 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдрийг дуусталх 3 хоногийн хугацаанд ХОМ-ийг цахимаар мэдүүлж, системд баталгаажуулна. **Үүний дараа “Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийн баталгааны маягт”**-ыг системээс хэвлэн, гарын үсэг зурж Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.
- ХОМ-ийг мэдүүлэх хуулийн хугацаа 2024 оны 5 дугаар сарын 23-нд дуусгавар болох тул Авлигатай тэмцэх газрын <https://meduuleg.iaac.mn/> цахим систем нь 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдрийг 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөрт шилжих шөнийн 00:00 цагт автоматаар хаагдана гэдгийг анхаарна уу.

ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ (ХОМ)-ИЙГ [https://meduuleg.iaac.mn/ ЦАХИМ СИСТЕМД](https://meduuleg.iaac.mn/) ХЭРХЭН МЭДҮҮЛЭХ ВЭ?

1-Р АЛХАМ: ЦАХИМ СИСТЕМД ЭРХ ҮҮСГЭХ, НЭВТРЭХ

Сонгуулийн ерөнхий хороо болон Авлигатай тэмцэх газрын даргын баталсан маягтын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нэр дэвшигчийн талаарх мэдээллийг үндэслэн ХОМ-ийг цахимаар мэдүүлэх эрхийг системд тусгайлан үүсгэх тул өөрийн ашиглаж буй цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар болон бусад шаардлагатай мэдээллийг хуулийн хугацаанд багтаан Сонгуулийн ерөнхий хороонд үнэн зөв гаргаж өгсөн байх шаардлагатай. Таны өгсөн цахим шуудангийн хаягаар системд нэвтрэх нууц үгийг илгээнэ.



Цахим системд нэвтрэх нэр буюу и-мэйл хаягаа өөрчлөх тохиолдолд АТГ-т **зөвхөн өөрөө хандаж** солиулна.



2-Р АЛХАМ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ МЭДҮҮЛЭХ

**ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН
БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ**

Нийр хүудс:

..... дугаар тойрог

ХАСЖОМ жагсаалт

| Он | Байгуулчига | Албан тушаал | Үүссэн огноо | Батал/важуулсан огноо | Төлөв | Үйлчил |
|------------|-------------|--------------|--------------|-----------------------|-------------------------------------|--------|
| 1 2019* | | | | | <input checked="" type="checkbox"/> | |

ХАРИУЦСАН АЖИЛТАН

- Оюн Нэр
- Албан утас

Мэдүүлгээ системийн “**засварлах**”
үйлдлийг сонгож, орлого, хөрөнгө
тус бүрээр мэдүүлж, хадгална.

Засварлах

Мэдүүлэг гаргагч
Гэр бүлийн байдал...
Орлого
Орон сууц
Тээврийн
Мал, аж ахуй

Үндсэн мэдээлэл

Ургийн овог :

Эзэг/эх-/ийн нэр :

Нэр :

Регистрийн дугаар :

Эрхэлж буй ажил
Боловсрол, мэргэжил

Байгууллагын нэр :

Боловсрол :

Албан тушаал :

Мэргэжил :

Холбоо барих :
Гар утас :

Шаардлагатай үед
холбоо барих :

Цахим шуудангийн хаяг :

Оршин суугаа газрын хаяг
Төрсөн газар
Үндсэн харьяа

Улс :

Аймаг/Нийслэл :

Улс :

Аймаг/Нийслэл :

Сум/Дүүрэг :

Аймаг/Нийслэл :

Сум/Дүүрэг :

Хаяг :

Сум/Дүүрэг :

Хаяг :

Хаяг :

Хадгалах
Хаах

ХОМ-ийг бөглөхдөө энэхүү гарын авлагын 16-23 дугаар хуудсанд байгаа загвар жишээнээс харж, үнэн зөв, дэлгэрэнгүй мэдүүлнэ.

Та өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг мэдүүлэхдээ орон сууц, газар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар, хадгаламж, эзэмшиж буй дансны мэдээлэл зэрэг шаардлагатай баримт бичгийг урьдчилан бэлтгэж, бэлэн болгосон байхыг анхаарна уу.

3-Р АЛХАМ. ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БАТАЛГААЖУУЛАХ

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН
БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ

Нийр хүчин:

| ХАРИУЦСАН АЖИЛТАН | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|-------------|-----------------------|--------------|-----------------------|------|--------|-------------|--------------|--------------|-----------------------|------|--------|------------|-------|-------|-------|-------|---|--|
| дугаар тойрог | | Сэргийн нэр: _____ | | Ажлын утас: _____ | | | | | | | | | | | | | | | |
| Дэлгэрэнгүй | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ХАСКОМ жагсаалт <table border="1"> <thead> <tr> <th>Он</th> <th>Байгууллага</th> <th>Албан тушаал</th> <th>Туссан огноо</th> <th>Баталгаажуулсан огноо</th> <th>Таны</th> <th>Үйлдэл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1 2019*</td> <td>_____</td> <td>_____</td> <td>_____</td> <td>_____</td> <td>X</td> <td></td> </tr> </tbody> </table> | | | | | | Он | Байгууллага | Албан тушаал | Туссан огноо | Баталгаажуулсан огноо | Таны | Үйлдэл | 1 2019* | _____ | _____ | _____ | _____ | X | |
| Он | Байгууллага | Албан тушаал | Туссан огноо | Баталгаажуулсан огноо | Таны | Үйлдэл | | | | | | | | | | | | | |
| 1 2019* | _____ | _____ | _____ | _____ | X | | | | | | | | | | | | | | |

Мэдүүлэгчийн мэдээлэл

| | | |
|----------------|---------------|--------------------|
| Эзлэх/ийн нэр: | Нэр: | Регистрийн дугаар: |
| Байгууллага: | Албан тушаал: | |

ХОМ-ийн мэдээлэл

| | | | | | | |
|--------------------------|-------------------|------------------|-----------|------------------|---------------|-------|
| Мэдүүлэгч гаргагч | Гэр бүлийн бэлдэл | Орлого | Орон сууц | Тээврийн хөрөсөн | Мал, алж аюул | Газар |
| Ургийн овог | _____ | Энэгээ хийн нэр | _____ | Овдийн нэр | _____ | |
| Регистрийн дугаар | _____ | Гар утас | _____ | Имэйл хаяг | _____ | |
| Оршин суугаа газрын хаяг | _____ | Ажлын утас | _____ | | | |
| | _____ | Гэрийн утас | _____ | | | |
| Боловсрон, мэргжин | _____ | Байгууллагын нэр | _____ | | | |
| Төрсөн газар | _____ | Албан тушаал | _____ | | | |
| Үндсэн харьяа | _____ | | | | | |

ХОМ харах

ХОМ харах

“ХОМ харах” товчийг дармагц Таны ХОМ-ийг PDF хэлбэрт хөрвүүлж системээс татна.



1.1 Мэдүүлэг гаргагч

| | | | | | |
|---------------------------|--|-----------------------------|--|-------------|--|
| Үргийн овог: | | Эзэг эхийн нэр: | | Өөрийн нэр: | |
| Регистрийн дугаар: | | Гар утас: | | Имайл хаяг: | |
| Оршин суугаа газрын хаяг: | | Ажлын утас: | | | |
| Боловсрол, мэргжил: | | Гэрийн утас: | | | |
| Терсен газар: | | Байгууллагын нэр: | | | |
| Үндсэн харьцаа: | | Газар, хэлтэс, тасаг, алба: | | | |
| | | Албан тушаал: | | | |

Баталгаажуулах

XOM харах Баталгаажуулнах Хах

Үүний дараа “ХОМ харах” товчны хажууд “Баталгаажуулах” товч гарч ирэх бөгөөд уг товчийг дарж, мэдүүлгээ баталгаажуулна. Мэдүүлгээ баталгаажуулмагц “Таны ХОМ амжилттай баталгаажлаа” гэсэн мэдэгдэл харагдана.

| | | | | | |
|-----------------|--|---------------|--|--------------------|--|
| Эзэг/эхийн нэр: | | Нэр: | | Регистрийн дугаар: | |
| Байгууллага: | | Албан тушаал: | | | |

Таны ХОМ амжилттай баталгаажлаа.

1.1 Мэдүүлэг гаргагч

| | | | | | |
|---------------------------|--|-----------------------------|--|-------------|--|
| Үргийн овог: | | Эзэг эхийн нэр: | | Өөрийн нэр: | |
| Регистрийн дугаар: | | Гар утас: | | Имайл хаяг: | |
| Оршин суугаа газрын хаяг: | | Ажлын утас: | | | |
| Боловсрол, мэргжил: | | Гэрийн утас: | | | |
| Терсен газар: | | Байгууллагын нэр: | | | |
| Үндсэн харьцаа: | | Газар, хэлтэс, тасаг, алба: | | | |
| | | Албан тушаал: | | | |

Баталгаажуулнах XOM харах Хах

| | | |
|------------------|---------------|--------------------|
| Эзэрхийгийн нэр: | Нэр: | Регистрийн дугаар: |
| Байгууллага: | Албан тушаал: | |

Таны ХОМ амжилттай баталгаажлаа.

| Мэдүүлэг гаргасан | Гэр бүтэйн байдал | Орлогын | Орон сууц | Тээврийн хөдөлгөөн | Мал, алж асуудлын | Газар |
|-----------------------------|-------------------|----------------------------|-----------|--------------------|-------------------|-------|
| 1.1 Мэдүүлэг гаргасч | | | | | | |
| Ургийн овог | | Эзэг эхийн нэр | | | Өөрийн нэр | |
| Регистрийн дугаар | | Гэр утас | | | Имойл хаяг | |
| Оршин суугаа газрын хаяг | | Ажлын утас | | | | |
| | | Гэрийн утас | | | | |
| Боловсрол, мэргжил | | Байгууллагын нэр | | | | |
| Төрсөн газар | | Газар, хэлтэс, тасаг, алба | | | | |
| Үндсэн харьцаа | | Албан тушаал | | | | |

Баталгааны маягт

Баталгааны маягт ХОМ харх Хөвх

Үүний дараагаар **“Баталгааны маягт”** товчийг сонгоход системээс PDF хэлбэрээр уг **маягтыг харуулах** ба түүнийг хэвлэн **гарын үсгээ зурж, СЕХ-нд хүргүүлнэ.**

PDF

БАТАЛГААНЫ МАЯГТ

/Сонгуульд нэр дэвшигчийн хэрэng, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/

| | |
|---|--|
| Дугаар:..... |он.....сар.....өдөр |
| /Баталгааны маягтыг хүзүүлээн өвсөн оноос/ | |
| /тойргийн дугаар/ | Нэр дэвшигчийн /эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр |
| (https://meduileg.iac.mn/ системд бүртгээдсэн цахим шууданын хаяг) | |
| /Регистрийн дугаар/ | |
| ХОМ мэдүүлсэн тайлант он:.....2023 | |
| ХОМ мэдүүлэх эрхийг цахимд үүсгэсэн огноо: | |
| ХОМ-ийг цахим системд баталгаажуулсан огноо: | |
| /эцэг/эх/-ийн нэр /өөрийн нэр/ миний бие Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дахь хэсэгт заасны дагуу Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын (https://meduileg.iac.mn/) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлсэнээ баталж байна. Хөрөнгө, орлогын мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвэл хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. | |
| Баталгаа гаргасан, Нэр дэвшигч: | |
| /Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр | |
|он.....сар.....өдөр | |
| /Баталгааны маягтыг хүзүүлээн өвсөн оноос/ | |



СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ ЗАГВАР ЖИШЭЭ

СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Нэг. Мэдүүлэг гаргагч, гүүний гэр бүлийн байдал:

| 1.1 Албан тушаал: Нэр дэвшигч | | |
|--|--|------------------------|
| Ургийн овог: Боржигон | Эцэг/эхийн нэр: Дондог | Нэр: Болдбаяр |
| Регистрийн дугаар: | Иргэний үнэмлэхийн дугаар: | |
| Оршин суугаа газрын хаяг: БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны *** тоот | Гар утас: 9999-9999 Ажлын утас: 7011-0252 Гэрийн утас: 7011-2489 | Цахим шуудангийн хаяг: |
| Боловсрол, мэргэжил: бакалавр, эрх эзүйч | Байгууллагын нэр: УИХ-ын ... дугаар тойрог | |
| Төрсөн газар: Архангай, Эрдэнэбулган сум | | |
| Үндсэн харьяа: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | Албан тушаал: Нэр дэвшигч | |

| 1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал | | | | | |
|--|------------------------|-------------------|---|--|---|
| Гэр бүлийн байдал | Эцэг /эх/-ний нэр, нэр | Регистрийн дугаар | Төрсөн газар, үндсэн харьяа | Эрхэлж байгаа ажил, албан тушаал | Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг |
| Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч | Очирбатын Энхцэцэг | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | “.....” ХХК-ийн ерөнхий захидал | Ажлын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Маргад центр 545 тоот. Гэрийн хаяг: Баянгол дүүргийн 5-р хороо, 10 дугаар хороолол, 9А байрны *** тоот |
| Хүүхэд | Болдбаярын Тэмүүлэн | | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Дээд сургуульд оюутан | БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны *** тоот |
| | Болдбаярын Хүслэн | | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Баянгол дүүргийн 13 дугаар дунд сургуульд сургач | БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны *** тоот |
| Эцэг | -- | - | - | - | -- |
| Эх | - | - | - | - | - |

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтранамьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

Хоёр. Хөрөнгө, орлого:

| 2.1. Орлого | | | | |
|-------------|--|-------------|----------------------|--|
| № | Орлогын төрөл | Орлогын дүн | | Орлогын эх үүсвэр |
| | | өөрийн | гэр бүлийн гишүүдийн | |
| 1 | Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 19 024 856 | 15 650 273 | Тухайн жилд авсан өөрийн болон эхнэрийн нийт цалин хөлс |
| 2 | Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/ | 720 850 | - | Үр дүнгийн гэрээний урамшуулал болон "Төрийн албаны тэргүүний ажилтан"цол тэмдгээр шагнуулсаншагналын орлого |
| 3 | Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/ | 8 250 000 | - | Төмс болон чацаргана тариалж, борлуулсны орлого |
| | Хөрөнгийн орлого /турээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/ | - | 2 234 561 | Эхнэрийн хугацаатай хадгаламж дахь хүүгийн орлого |
| | | - | 7 200 000 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, "Өнөр" хотхоны 10-р байр, *** тоот, 34 мкв талбайтай 1 өрөө байрыг иргэн Б.Бадамтай түрээсийн гэрээ байгуулж, хөлслүүлсэн түрээсийн орлого |
| | | 5000 000 | 15 000 000 | "....." ХХК-ийн ногдол ашиг |
| 5 | Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/ | 300 000 | - | "BBBB" ХК- ийн 500ш хувьцааг "УЛС" ХК-д худалдан борлуулсны орлого |
| | | - | 35 265 000 | Япон улсаас оруулж ирсэн Ниссан Тийда автомашиныг 2023.02.25-нд иргэн Л.Доржид 11,2 сая төгрөгөөр, 2023.05.03-нд иргэн Б.Сүхбатад 13,6 сая төгрөгөөр Төёота Гранд Марк-П автомашиныг, 2023.05.03-нд иргэн У.Ундрахад 10.5 сая төгрөгөөр Төёота Витэ маркийн суудлын автомашиныг тус тус худалдан борлуулсан. |
| | | 3 600 000 | - | 2023 оны 09-р сард Архангай аймгийн Ихтамир сумын иргэн Х.Дамбад 30 толгой хонь худалдсан |
| 6 | Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/ | 12 000 000 | - | Эмчилгээний зардалд зориулж ах дүү, төрөл садан, наиз нөхөд болон байгууллага, хамт олноос егсэн хандив тусламжийн орлого |



| | | | | |
|---|---|---------------|------------|--|
| 7 | Бусац орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл түүрвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тогтолт зохион байгуулах, тэдгээрт орлцох замаар олсон орлого, тэдгээртэй ацилттах бусац орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мэнгэний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мэнгэн тэтгэмжийн орлого / | - | 240 000 | 2023 онд төрөөс олгосон хүүхдийн мөнгө |
| 8 | Нийт дүн | 48 895 706 | 75 469 798 | |

Тайлбар: Тайлант хугацаанд олсон өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлогыг бичнэ.

2.2. Хөрөнгө, зээл

Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

| 2.2.1. Орон сууц, барилга, байгууламж | | | | | | |
|---------------------------------------|--|---|--|--|--------------------------------------|---|
| № | Орон сууц, барилга, байгууламж- ийн төрөл | Хийц, талбай | Байршил / хаяг/ | Зах зээлийн үнэлгээ / төгрөг/ | Бүртгэлийн гэрчилгээний дугаар | Эх үүсвэрийн тайлбар |
| 1 | Нийтийн орон сууц | Угсармал, 60 мкв, 3 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10дугаар хороолол, 9А байрны * * * тоот | 80 000 000 | Y-2204689729 | Эцэг М. Доржоос евлөгдсөн. Өмчлөгч Д.Болдбаяр |
| 2 | Авто гарааш | Тоосгон, 12 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10дугаар хороолол, 9А байрны дэргэд | 10 000 000 | Y-2304680698 | 2005 онд 3 сая төгрөгөөр худалдаж авсан. Хьюндэй Соната II маркийн автомашин зарсан орлогоор авсан. |
| 3 | Зуслангийн байр | Палкан, 60 мкв, манкардтай, 2 өрөө | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | 25 000 000 | Y-2304680698 | 2007-2010 онд 15 сая төгрөгийн өртөтэйгээр өөрсдөө барьсан. Тухайн үед банкны 10 сая төгрөгийн зээл авсан. Үлдсэн мэнгийг гэр бүлийн гишүүдийн цалин, хуримтлал, компанийн ногдол ашгийн орлогоор бий болгосон. |

| | | | | | | |
|----------|-------------------|---------------------------------------|--|------------|---------------|--|
| 4 | Нийтийн орон сууц | Төмөр бетонон цутгамал, 34мкв, 1 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, “Өнөр” хотхоны 10 дугаар байрны 65 тоот | 40 000 000 | Y-2203512689 | 2011 онд 40 сая төгрөгөөр худалдаж авсан. Эх үүсвэр нь Орон сууц санхүүжилтийн корпорациас 35 сая төгрөг. Үлдсэн 5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бий болгосон. Эхнэр, хадам эцэг, хадам ээжийн дундын өмчлөл. |
| 5 | Авто зогсоол | 15 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, “Өнөр” хотхоны 10 дугаар байрны зоорийн давхарт 15 тоот зогсоол | 14 000 000 | Y-22016582568 | Японоос оруулж ирсэн автомашин зарсан орлогоо 2010 онд 10 сая төгрөгөөр худалдаж авсан. |
| Нийт дүн | | | 159 000 000 | | | |

Тайлбар: “Орон сууц, барилга, байгууламжийн төрөл” хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” багананд тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.

Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

| 2.2.2. Тээврийн хэрэгсэл | | | | | |
|--------------------------|--|-------------|--|--------------------------------|--|
| № | Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он | Тоо, ширхэг | Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр | Зах зээлийн үнэлгээ / төгрөг / | Эх үүсвэрийн тайлбар |
| 1 | Тоёота Клюгер, 2020 онд үйлдвэрлэсэн | 1 ш | АЯ123456, УНП 12-34, Д.Болдбаяр | 30 000 000 | 2020 онд 30 сая төгрөгөөр худалдаж авсан. Худалдаас хөгжлийн банкны хадгаламжаас 2 сая төгрөг, “.....” ХХК-ийн ногдол ашгаас 5 сая төгрөг, урьд нь хэрэглэж байсан Гранд Марк II маркийн автомашиныг борлуулсан 8 сая төгрөгөөр эх үүсвэрийг бий болгосон. |
| 2 | Тоёота Приус, 2022 онд үйлдвэрлэсэн | 1 ш | АЯ654321 ,УБП 34-56, О.Энхцэцэг | 20 000 000 | 2009 онд 20 сая төгрөгөөр хадам эцэг, эхээс эхнэр О.Энхцэцэгт худалдаж авчэгсөн. |
| Нийт дүн | | | 50 000 000 | | |

Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.



Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

| 2.2.3 Мал, аж ахуй | | | | | |
|--------------------|----------------------|----------------|-------------------------------------|--|--|
| № | Төрөл | Тоо, толгой | Зах зээлийн үнэлгээ / төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар | Байршил |
| 1 | Хонь | 126 | 11 340 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд өгсөн 20 хонь, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 2 | Ямаа | 85 | 7 650 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 ямаа, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 3 | Адуу | 19 | 5 700 000 | Аав М. Доржоос 2005 онд 5 морь өгсөн, 2007 онд Хэнтий аймгаас 3 унагатай гүүг 3 сая төгрөгийн хуримтлалын орлогоор худалдаж авсан, төлөөр өссөн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| 4 | Хурдан удмын адуу | 5 | 5 000 000 | Найз нөхдөөс бэлэглэсэн. | Архангай аймгийн Ихтамир суманд нагац ах М.Рагчаагийнд байдаг. |
| Нийт дун | | | 29 690 000 | | |

Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт өөрийн болон гэр булийн гишүүдийн таван хошуу малаасгадна туслах аж ахуйн чиглэлийн гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.

Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 2.2.4 Газар | | | | | |
|-------------|--|--------------------------|---|-------------------------------------|--|
| № | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, өн, сар, өдөр | Төрөл, хэмжээ | Байршил /бус нутаг/, хаяг | Зах зээлийн үнэлгээ / төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар |
| 1 | ГД:987654, СБД-ийн Засаг даргын 2004.10.24-ний өдрийн 358 дугаартай захирамжаар | Өмчлөх эрхтэй, 0,04га | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | 6 000 000 | Хуулийн дагуу улсаас үнэгүйавсан. |
| 2 | ГД:123456, Нийслэлийн Засаг даргын 2008.12.19-ний өдрийн 147 дугаартай захирамжаар | Эмчлэх эрхтэй, 0,07га | Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Тахилгын аманд | 4 000 000 | 2008 онд цалин, хуримтлалын орлогоор 500 000 төгрөгөөр худалдаж авсан. |
| 3 | Баянгол дүүргийн Засаг даргын 2006.10.24-ний өдрийн 322 дугаартай захирамжаар | Ашиглах эрхтэй, 108 мкв | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10-р хороолол, 9Абайрны дэргэд | 10 000 000 | Гэрээгээр түр ашиглаж байгаа. |
| Нийт дун | | | | 20 000 000 | |

Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл

| № | Хөрөнгийн нэр | Үнэлгээ /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн болон бусад тайлбар |
|---|-------------------------------------|------------------|-----------------|---|
| 1 | Шүрэн толгойтой халтар манан хөөрөг | 20 000 000 | Д.Болдбаяр | Өвөө Н.Мягмааас 2003 онд өвлөж авсан, өөрийн эзэмшилд хэрэглэдэг. |
| 2 | Мөнгөн тоногтой хуучны эмээл хазаар | 5 000 000 | Б.Тэмүүлэн | Эцэг М.Доржоос хүү Б.Тэмүүлэнд өвлөгдсөн. |
| | Нийт дүн | 25 000 000 | | |

Тайлбар: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшиж, өмчилж, ашиглаж байгаа үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийг мэдүүлнэ.

Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 2.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл | | | | |
|---|---|--------------|---------------------------|--|
| № | Банк, санхүүгийн байгууллагын нэр | Дүн /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн тайлбар |
| 1 | Худалдаа хөгжлийн банкны хугацаатай хадгаламж | 26 657 500 | О.Энхцэцэг | 2015 онд З сая төгрөгөөр хугацаагүй хадгаламжийн данс нээлгэсэн. Цалин хуримтлалын орлого, хөрөнгөе борлуулсны орлого, ... ХХК-ийн ногдол ашгийг хадгалуулсан мөнгө. Дансны дугаар: 4080462018 |
| 2 | Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт | 237 000 | Д.Болдбаяр | Цалингийн орлого. Дансны дугаар: 4512748912 |
| 3 | Хаан банк, хувийн харилцахданс | 2 345 000 | О.Энхцэцэг | Үйл ажиллагааны орлого, өдөр тутмын гүйлгээ хийгддэг. Дансны дугаар: 5074135496 |
| 4 | Бэлэн мөнгө | 680 000 | О.Энхцэцэг, Д.Болдбаяр | Цалин, үйл ажиллагааны орлогын 2023.12.31-ний өдрийн үлдэгдэл дүн. |
| | Нийт дүн | 29 899 500 | | |

Тайлбар: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ.

Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 2.2.7 Авлага | | | | |
|--------------|---------------------------------|--------------|--------------|--------------------------|
| | Хувь хүн, хуулийн этгээдийн нэр | Дүн /төгрөг/ | Хугацаа, хүү | Тайлбар |
| | Д.Дагвадорж | 3 000 000 | - | Найздаа түр зээлдүүлсэн. |
| | Нийт дүн | | | |

Тайлбар: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн авлагын талаар мэдүүлнэ.



Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 2.2.8 Зээл | | | | | | |
|------------|-----------------------------------|------------------------------------|---|---|-------------------------|---|
| № | Зээлдүүлэгчийн нэр, хаяг | Анх авсан зээлийн хэмжээ / төгрөг/ | Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн / төгрөг/ | Зээл авсан, бөлөн телж дуусах он, сар, өдөр | Зориулалт | Зээлийн барьцаа, батлан даагч |
| 1 | Орон сууц санхүүжилтийн корпораци | 35 000 000 | 4 236 890 | 2020.07.20-2030.07.20 | Орон сууц худалдан авах | Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, "Өнөр" хотхонаы 10 дугаар байрны * * * тоот |
| | Нийт дүн | 35 000 000 | | | | |

Тайлбар: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн авсан зээлийн талаарх мэдээллийг мэдүүлнэ.

а Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 2.2.9 Компани, нохөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт | | | | | | | |
|---|-------------------------------|---------------|----------------------------|---------------------------------------|--|-------------|--|
| № | Хуулийн этгээдийн нэр, хэлбэр | Хувьцааны тоо | Нэгж хувьцааны үнэ /төгрөг | Хувьцааг худалдаж авсан үнэ / төгрөг/ | Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан / төгрөг/ | Ногдол хувь | Эх үүсвэрийн тайлбар |
| 1 | "....."ХХК | 1000 ш | - | - | 1 000 000 | 100% | 2006 онд эхнэрийн хамт үүсгэн байгуулсан. О.Энхцэцгэл 75 хувийг, Д.Болдбаяр 25 хувийг тус тус эзэмшдэг. Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг. |
| 2 | "....."ХК | 148 ш | 568 | - | - | - | 1991 онд цэнхэр тасалбараар улсаас үнэтгүй өгсөн, өөрийн нэр дээр бүртгэлтэй. |
| | Нийт дүн | | | | 1 000 000 | | |

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыгмэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ.

Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшидэггүй бол /-/ тэмдэглэсээ хийх.

2.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл

| № | Төрөл | Эзэмшигчийн нэр | Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо | Тайлбар |
|---|----------------|-----------------|---|---|
| 1 | Зохиогчийн эрх | Д.Болдбаяр | Оюуны өмчний газар, 2010 он | "А А А" нэртэй ном бичиж, зохиогчийн эрх авсан. |

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.

2.3. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт

| № | Эх су рвалжийн нэр, хаяг | Бэлэг, үйлчилгээ, өв залгамжпалын төрөл | Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт | Үнэлгээ / төгрөг/ | Тайлбар |
|---|--------------------------|---|---|-------------------|---|
| 1 | Хандив, туслалцаа | - | Хандив, туслалцаа | 12 000 000 | Эмчилгээний зардалд зориулж ах дүү, төрөл садан, найз нөхөд болон байгууллага, хамт олноос өгсөн хандив тусламжийн орлого |
| | Нийт дүн | | | 12 000 000 | |

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: /Д.Болдбаяр/
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... оны ...дугаар сарын ... -ны өдөр



ГУРАВДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно. Тодруулбал, сонгуулийн сурталчилгаа 2024 оны 06 дугаар сарын 10-наас 06 дугаар сарын 26-ны өдрийг дуустал үргэлжилнэ.

Сонгуулийн сурталчилгаа явуулах арга, хэлбэр

- ✓ Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- ✓ Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- ✓ Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;
- ✓ Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- ✓ Ухуулах байр ажиллуулах;
- ✓ Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- ✓ Цахим орчин ашиглах;
- ✓ Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.
- ✓ Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчдод зар, урилга явуулсныг сурталчилгааны хэвлэлээс материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь А5 хэмжээнээс илүүгүй байна.
- ✓ Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.

Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах

- ✓ Сонгуулийн тойротг нэр дэвшигч нь нь сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.
- ✓ Сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн улсын дугаарыг аймаг, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлэн, таних тэмдгийг авч, ил харагдахуйц байрлуулна.
- ✓ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан таних тэмдэггүй авто машин, автобус, мопед, мотоцикл болон бусад тээврийн хэрэгслийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно.
- ✓ Сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэлд сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас, зурагт самбар, дэлгэц, уриа,



намын далбаа, чанга яригч байрлуулж болно.

Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх, тараах, хүргэх

- ✓ Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:
 - хоёр хэвлэлийн хуудас сонин;
 - хоёр хэвлэлийн хуудас сэтгүүл;
 - нэг хэвлэлийн хуудас ухуулах буюу зурагт хуудас.
- ✓ Нэг нам, эвслийн тойротг нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалаа нэгдмэл байдлаар хамтран гаргаж болно.
- ✓ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон байршилаас өөр газарт зурагт самбар байршуулахыг хориглоно. Зурагт самбар байршуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөлгчдийн хурлын цахим хуудаст хандан мэдэх боломжтой.
- ✓ “Нэг хэвлэлийн хуудас” гэж А4 бичгийн цаасны найман нүүрийг ойлгоно.
- ✓ Сурталчилгааны хэвлэмэл материалыг шуудангаар хүргүүлж болно.
- ✓ Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь брайль үсэгтэйгээр хэвлүүлж болно.
- ✓ Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.

Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

- ✓ Тойротг нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбарыг сум, дүүргийн Засаг дарга хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэнэ.
- ✓ Нэгдсэн самбарыг суманд хоёр, аймгийн төвийн суманд тав, хороонд дөрөвийгт байрлуулна.
- ✓ Нэгдсэн самбарт байрших нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байна.
- ✓ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зурагт самбар байрлуулах байршлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс тогтоож, нийтэд мэдээлнэ.
- ✓ Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.
- ✓ Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайл сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.
- ✓ Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.
- ✓ Зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.



Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан

- ✓ Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглааныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд багтаан хийнэ.
- ✓ Сонгогчтой хийх уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.
- ✓ Дараах байгууллага, хуулийн этгээд сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд нь зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй:
 - төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;
 - төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;
 - төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд.

Ухуулах байр ажиллуулах

- ✓ Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.
- ✓ Нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран нэг ухуулах байранд үйл ажиллагаа явуулж болно.
- ✓ Ухуулах байрыг дараах зорилгоор ажиллуулна:
 - Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, танилцуулах;
 - Сонгуулийн сурталчилгааны материалыг сонгогчдод тараах;
 - Уулзалт, хурал зохион байгуулах.

Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах

- ✓ Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ.
- ✓ Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна.
- ✓ Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно.
- ✓ Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглоно.
- ✓ Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байна.

- ✓ Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.
- ✓ “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-тай www.m-election.mn цахим хуудаст хандан танилцах боломжтой.

Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах

- ✓ Сонгуулийн сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглажболно:
 - 1.нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахимхуудас;
 - 2.цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас;
 - 3.бусад цахим хуудас.
- ✓ Нэр дэвшигч 1, 2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.
- ✓ 1, 3-т заасан цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.
- ✓ бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг тус тус хориглоно.
- ✓ Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны материалыг цахим хэлбэрээр буюу цахим шуудангаар сонгогчдод хүргүүлж болно.
- ✓ Нэр дэвшигч болон нам, эвсэл нь 1, 2-т заасан цахим хуудсаа санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө хаана.
- ✓ Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.
- ✓ “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-тай www.m-election.mn цахим хуудаст хандан танилцах боломжтой.

Хууль бус сурталчилгааг хориглох

- ✓ Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх;



- Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;
 - Сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;
 - Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;
 - Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;
 - Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;
 - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх;
 - Тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах.
- ✓ Улс төрийн намаас зөвхөн гишүүдийнхээ хүрээнд зохион байгуулсан сургалт, уулзалтыг сонгогчдын саналыг татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамааруулахгүй.
- ✓ Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.
- ✓ Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.
- ✓ Сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- Энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;
 - Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;
 - Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
 - Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
 - Оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;
 - Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.



- ✓ Нам, эвслийн дарга, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орох, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч ухуулах байр ажиллуулахыг хориглоно.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ЗАРДАЛ, ТҮҮНИЙГ ТАЙЛАГНАХ

4.1. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Сонгуулийн зардал

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, түүнчлэн нэр дэвшигч сонгуулийн мерийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны шууд болон шууд бус зардал гаргана.

Сонгуулийн зардлын дээд хэмжээ

Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн A/12 дугаар тушаалаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон. (хавсралт 1-ээс харна уу)

Сонгуулийн зардлын бүрдэл

Сонгуулийн зардал нь хандив, намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн хөрөнгөөс бүрдэнэ.

Сонгуулийн зардлын данс

- ✓ Нам, эвсэл болон сонгуулийн тойрогт нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.
- ✓ Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлж, зарцуулна.
- ✓ Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд сонгуулийн зардал цуглуулах, зарцуулахыг хориглоно.
- ✓ Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.
- ✓ Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө буюу 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.
- ✓ Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй.

Сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах

- ✓ Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусталх хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /цаашид сонгуулийн хууль гэх-/ийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.
- ✓ Нам нь эвсэл байгуулан сонгуульд оролцож байгаа бол эвслийн сонгуулийн зардлын дансанд сонгуулийн зардал шилжүүлэхээс бусад зориулалтаар сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргахыг хориглоно.

Сонгуулийн хандив

- ✓ Сонгуулийн хандив нь мөнгөн, мөнгөн бус хэлбэртэй байна.
- ✓ Хандивлагч энэ хуульд заасан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байж болно.
- ✓ Сонгуулийн хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасныдагуу тогтоосон нэр дэвшигчээс тойротг зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна.

Мөнгөн хандив

- ✓ Мөнгөн хандив нь иргэний хувьд арван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд гучин сая төгрөг хүртэл байна.
- ✓ Иргэн, хуулийн этгээдээс нам, эвсэлд, эсхүл сонгуулийн тойротг нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш сонгуулийн үйл ажиллагаанд нь зориулан сонгуулийн зардлын дансанд хандив өгч болно.
- ✓ Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.
- ✓ Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.
- ✓ Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно.

Мөнгөн бус хандив

- ✓ Мөнгөн бус хандивт үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшигүүлэх болон үйлчилгээ үзүүлэх хамаарна.
- ✓ Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.



- ✓ Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.
- ✓ Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

Хандив өгөх, хүлээн авахыг хориглох

- ✓ Дараах этгээд хандив өгөхийг хориглоно:
 - гадаад улс буюу гадаадын байгууллага, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;
 - гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;
 - 18 нас хүрээгүй хүн;
 - төрийн болон орон нутгийн өмчйт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
 - шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;
 - үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага;
 - байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.
- ✓ Хандив өгөхийг хориглосон этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлнэ. Үүнийг зөрчиж хүлээн авсан хандивыг улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.
- ✓ Нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвслийн болон нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.
- ✓ Нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

4.2. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ТАЙЛАГНАХ

Сонгуулийн зардлын тайлан

- ✓ Сонгуулийн зардлын тайланда орлого ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.
- ✓ Сонгуулийн зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийн санхүүгийн тайлан байна.
- ✓ Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ. (Нам, эвсэл 2024.08.12-ны дотор, нэр дэвшигч 2024.07.28-ны дотор)
- ✓ Зардлын тайланг дараах үзүүлэлтээр гаргана:
 - сонгуулийн зардлын дансанд орсон орлогын нийт хэмжээг сонгуулийн хуулийн 49.2-т заасан хөрөнгийн эх үүсвэр болон гүйлгээ тус бүрээр;
 - хандивлагч иргэн, хуулийн этгээдийн сонгуулийн хуулийн 54.4-т заасан мэдээлэл болон хандивын хэмжээ, хэлбэр;
 - зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт;
 - үлдэгдлийн хэмжээ, байршил;
 - сонгуулийн зардлын данснаас зарлага гаргаж эхлэхийн өмнөх мөнгөн хөрөнгийн хэмжээ.
- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/45 дугаартай “Журам, маягт, заавар батлах тухай” тушаалтай www.legalinfo.mn цахим хуудаст хандан танилцах боломжтой.

✓

Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал

- ✓ Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ. (Нам, эвсэл 2024.10.11-ний дотор, нэр дэвшигч 2024.09.26-ны дотор)
- ✓ Нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө буюу 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.



Хариуцлага

- ✓ Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- ✓ Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- ✓ Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- ✓ Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 02 дугаар
сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаалын хавсралт

Хавсралт 1

| № | Тойргийн дугаар, аймгийн нэр | Мандатын тоо | Нам, эвслийн нийт зардал | Нэр дэвшигчийн нийт зардал |
|----|--|--------------|--------------------------|----------------------------|
| 1 | 1-р тойрог Архангай, Баянхонгор, Өвөрхангай | 9 | 574,308,107.7 | 1,378,983,796.9 |
| 2 | 2-р тойрог Говь-Алтай, Завхан, Увс, Ховд | 10 | 659,785,964.3 | 1,526,054,380.9 |
| 3 | 3-р тойрог Баян-Өлгий | 3 | 261,992,747.7 | 1,058,746,682.1 |
| 4 | 4-р тойрог Булган, Орхон, Хөвсгөл | 8 | 487,060,273.9 | 1,230,485,598.1 |
| 5 | 5-р тойрог Дархан-Уул, Сэлэнгэ, Төв | 10 | 498,096,846.4 | 1,064,320,563.5 |
| 6 | 6-р тойрог Дорнод, Сүхбаатар, Хэнтий | 7 | 474,369,193.9 | 1,164,854,766.7 |
| 7 | 7-р тойрог Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь | 7 | 469,951,439.9 | 1,098,521,799.6 |
| 8 | 8-р тойрог Баянзүрх | 5 | 640,984,301.5 | 1,164,541,061.2 |
| 9 | 9-р тойрог Баянгол | 3 | 488,776,433.2 | 1,099,697,551.2 |
| 10 | 10-р тойрог Сүхбаатар, Чингэлтэй | 6 | 569,801,654.6 | 894,773,229.1 |
| 11 | 11-р тойрог Сонгинохайрхан | 5 | 590,595,221.8 | 968,576,569.5 |
| 12 | 12-р тойрог Хан-Уул | 3 | 435,352,153.7 | 1,121,664,599.4 |
| 13 | 13-р тойрог Багануур, Багахангай, Налайх | 2 | 283,456,891.3 | 994,256,563.7 |
| | НИЙТ | 78 | 6,434,531,229.9 | - |

---oo0oo---



ТАВДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ЦАХИМ СИСТЕМЭЭР НЭР ДЭВШИГЧ БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ “E-ELECTION.MN”-ИЙН ТУХАЙ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос үйл ажиллагаагаа цахимжуулах хүрээнд 2022 оноос хойш сонгуулийн мэдээллийн сангийн цахим систем www.e-election.mn-ийг хөгжүүлэн ажиллаж байна. Иймд нэр дэвшигч нь цаасаар эсхүл **цахимаар НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ-ийг илгээх** боломжтой.

Нэр дэвшигч www.e-election.mn-д хэрэглэгчийн эрхээр нэвтрэснээр холбогдох мэдээлэл, лавлагааг ХУР системээр дамжуулан авах бөгөөд АТГ-ын Хөрөнгө орлогын мэдүүлэг, бусад хавсаргах шаардлагатай баримт бичгийг системд оруулан **НЭР ДЭВШИХ ХҮСЭЛТЭЭ ЦАХИМААР ИЛГЭЭНЭ**.

Системд хандах эрхийг олгохдоо: нам, эвслээс нэр дэвшигч бол тухай нам эвслийн албан бичгийн дагуу “**Нам, эвслийн бүртгэл хариуцсан ажилтан**”-ыг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэж, эрх олгоно. Бие даан нэр дэвшигч бол Сонгуулийн ерөнхий хорооны “**Нэр дэвшигчийн бүртгэл хариуцсан албан хаагч**” хэрэглэгчийн эрхийг үүсгэж өгнө.

Системээс Сонгуулийн ерөнхий хороо болон аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод эрхийнхээ хүрээнд нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч болон сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийг цахимаар бүртгэж үнэмлэх, гэрчилгээг баталгаажуулан олгоно.

НЭР ДЭВШИГЧИД ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮСГЭХ:

- ✓ “Нам, Эвслийн бүртгэл хариуцсан ажилтан”-ыг Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцох нам, эвслийн ирүүлсэн албан бичигт үндэслэн системд бүртгэнэ.
- ✓ Бие даан нэр дэвшигчигчийг Сонгуулийн ерөнхий хорооны “Нэр дэвшигчийн бүртгэл хариуцсан албан хаагч” бүртгэж, системд нэвтрэх эрхийг бүртгүүлсэн и-мэйл хаягт илгээнэ.



1. СИСТЕМД НЭВТРЭХ

Сонгуулийн мэдээллийн цахим системд нэвтрэхдээ дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хэрэглэгч интернэт хөтөч дээр <https://www.e-election.mn/login> гэсэн системийн хаягийг бичихэд системийн Нүүр хуудас нээгднэ.
- Нүүр хуудасны Нэвтрэх хэсэг дэх Хэрэглэгчийн нэр, Нууц үг талбаруудад өөрийн хэрэглэгчийн мэдээллийг оруулаад Нэвтрэх товч дарж системд нэвтрнэ.
- Нам, эвслийн бүртгэл хариуцсан ажилтан нэр дэвшигчийн Регистрийн дугаар, Овог нэр цахим шуудангийн хаягийн мэдээллийг системд бүртгэнээр Хэрэглэгчийн нэр, Нууц үг нэр дэвшигчийн бүртгүүлсэн хаягт илгээгднэ.

Сонгуулийн мэдээллийн цахим системийн нэвтрэх эрх Inbox



e-election@gec.gov.mn
to Unaraa900 ▾

Эрхэм нэр дэвшигч УНАРАНХАНД танд энэ өдрийн мэнд хүргэе.

Та доорх холбоосор нэвтрэх өөрийн дэлгэрэнгүй мэдээллийг оруулна уу.

| | |
|--------------|--|
| Нэвтрэх нэр: | Unaraa900@gmail.com |
| Нууц үг: | www.e-election.mn |

Вэб холбоос



Зураг 1. Сонгуулийн мэдээллийн цахим системийн нэвтрэх эрх ирүүлсэн цахим шуудан

The screenshot shows the login page of the e-election system. At the top right is the logo of the General Election Commission of Mongolia. Below it is a section titled "Нэвтрэх хэсэг" (Login section) with fields for "Системийн хэрэглэгч" (User), "Хэрэглэгчийн нэр" (Name), and "Нууц үг" (Password). There are also buttons for "Нэвтрэх" (Login) and "Дангаар нэвтрэх" (Guest login). The bottom right corner indicates the system is "Powered by Veritech ERP".

Зураг 2. Системийн нүүр хуудас



2. НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БҮРТГЭХ

Системд нэр дэвшигчийн эрхээр ороход Ерөнхий мэдээлэл хэсэг цонх нээгдэнэ.

Нэр дэвшигчийн Ерөнхий мэдээлэл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ерөнхий мэдээлэл
- Гэр бүлийн байдал
- Боловсролын талаарх мэдээлэл
- Ажлын туршлага
- Шүүхийн лавлагаа
- Цагдаагийн лавлагаа
- Татварын лавлагаа
- Шаардлагатай бичиг баримт хавсаргах

Зураг 3. Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл

ҮЙЛДЭЛ 1. Нэр дэвшигчийн ерөнхий мэдээлэл бүртгэх

Нэр дэвшигчийн мэдээлэл хэсэгт тухайн иргэний мэдээлэл Нам эвслийн ажилтан бүртгэсэн мэдээлэл харагдана.

- ХҮР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар ХҮР систем дэх таны хувийн мэдээлэл бөглөгднө.
- Зураг, Утасны дугаарын мэдээллийг гараас оруулан Хадгалах товч даран дараагийн хэсэг рүү шилжинэ.



СОНГУУЛЬ

Асуудал Ерөнхий мэдээлэл +

Гэр бүлийн байдал Болонхорын талаарх мэдээлэл Ажлын туршлага Шүүхийн Лавлагага Цэдэгийн Лавлагага Татварын Лавлагага Шаардлагатай бичиг баримт хавсралт

Нэр дэвшигчийн мэдээлэл

ХүР-с мэдээлэл дуудах

Зураг: No file selected

Регистрийн дугаар: УЧР/2024/12345

Эзгэг (хүчин нэр): Чингисхан

Фөрөйн нэр: Чингисхан

Хамгийн: УЧР_Чингис_Түүхийн_Информацийн_Агентствийн_Урьдчилсан@GMAIL.COM

Имайл: Uchraa123@gmail.com

Утас: Утас

Нэр дэвшигчийн мэдээлэл

Хуудас огноо: 01.01.2024 - 31.12.2024

Саналын хувьдэх нэр: Улсын Их Хурлын 2024 оны эзлэх сон...蒙古 Адьин Нам

| № | Төлөө | Сонгууль | Нам, заслаа | Төлөөр | Тогтолцоо |
|---|-----------|---|-------------|--------|--------------------------|
| 1 | Бүртгэсэн | Улсын Их Хурлын 2024 оны эзлэх сон...蒙古 Адьин Нам | | 1 | Өвөрхангай аймгийн Арайн |

Зураг 4. Ерөнхий мэдээлэл**ҮЙЛДЭЛ 2.** Гэр бүлийн байдал

- ХҮР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар нэр дэвшигчийн гэрлэлтийн мэдээлэл ХҮР-аас дуудагдана.
- Бусад гэр бүлийн гишүүдийн мэдээллийг Мөр нэмэх товч дээр даран гараас бөглөнө.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Иргэний гэрлэлтийн мэдээлэл дамжуулах сервисээс ирсэн мэдээлэл нь хэсгийн мэдээллийг шалгаж мэдээлэл үнэн зөв бол **Тийм** буруу бол **Үгүй** гэсэн сонгоно.

СОНГУУЛЬ

Асуудал Ерөнхий мэдээлэл +

Гэр бүлийн байдал Болонхорын талаарх мэдээлэл Ажлын туршлага Шүүхийн Лавлагага Цэдэгийн Лавлагага Татварын Лавлагага Шаардлагатай бичиг баримт хавсралт

Гэр бүлийн байдал

+ Мөр нэмэх

| № | Таны ху боловх | РД | Барийн нэр | Эзгэг (хүчин нэр) | Утас |
|---|----------------|----------------|----------------|-------------------|------|
| 1 | Нохир | УЧР/2024/12345 | Аюубар | Ганбаттар | Утас |
| 2 | - Сонхж - | РД | Өвөрхангай нэр | Эзгэг (хүчин нэр) | Утас |

Иргэн гаралтийн мэдээлэл дамжуулах сервисээс ирсэн мэдээлэл

| № | ҮЛС | Гаралсан огноо | Гаралжсан дугаар | Сервисийн ярийн байгаа мэдээллийг зөвшилжүүлэх эсэх | Сервис дуудсан огноо |
|---|--------|-------------------|------------------|--|----------------------|
| 1 | Монгол | -09-00 00:00:00.0 | 1125830026 | Тийм <input checked="" type="radio"/> Үгүй <input type="radio"/> | 2024-04-24 16:28:31 |

Зураг 5. Гэр бүлийн байдал бүртгэх цонх



ҮЙЛДЭЛ 3. Боловсролын талаарх мэдээлэл бүрглөх

- ХҮР-с мэдээлэл дуудах товч дарснаар ХҮР системд бүртгэлтэй их, дээд сургууль болон бүрэн дунд боловсролын мэдээлэл дуудагдана.
- Элссэн огноо, Дипломын дугаарын мэдээллийг бүртгэнэ.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Боловсролын мэдээлэл нь ирээгүй тохиолдолд Мөр нэмэх товч дээр даран боловсролын мэдээллийг бүртгэнэ үү.

| № | Сургуулийн нэр | Хүчин | Эзслэх огноо | Дуусах огноо | Дипломын дугаар | Эзжийн зэрэг |
|---|---|-------------|--------------|--------------|-----------------|---------------------------------|
| 1 | Мус / Монгол Улсын Их Сургуул / Комьютерийн Ухаан | Хүчинчилэгч | 2016-09-01 | 2022-01-01 | 112345646 | Дипломын болон Бакалаврийн дээд |
| 2 | Сургуулийн нэр | Хүчинчилэгч | Эзслэх огноо | Дуусах огноо | Дипломын дугаар | - Сонгох - |

Зураг 6. Боловсролын талаарх мэдээлэл бүртгэх цонх

ҮЙЛДЭЛ 4. Ажлын туршлага мэдээлэл бүртгэх

- Мөр нэмэх товч дээр дарснаар мэдээлэл оруулах шинэ мөр нэмэгдэнэ.
- Ажил албан тушаалын мэдээлэлээ бүртгэж оруулна.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.

| № | Байнуулатайн нэр | Салбар нийтийн нэр | Албан тушаал | Орсон огноо | Гарсан огноо |
|---|------------------|--------------------|--------------|-------------|--------------|
| 1 | Байнуулатайн нэр | Салбар нийтийн нэр | Албан тушаал | Орсон огноо | Гарсан огноо |

Зураг 7. Ажил албан тушаалын мэдээллэл бүртгэх цонх

ҮЙЛДЭЛ 5. Шүүхийн лавлагаа

Банк бусад хуулийн этгээд , иргэнд төлбөл зохих зээл, барьцаа батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүх, арбитрт хариуцагчаар татагдан хэрэг хянан шийдвэрлэх оролцож байсан эсэх талаарх мэдээлэл.

- УИХ -н сонгуульд нэр дэвшиж байгаа тохиолдолд Улсын дээд шүүхийн лавлагааг шаардлагатай бичиг баримт хавсаргах цэсээр заавал хавсаргана.
 - ХҮР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар
- 1.Шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй эсэх мэдээлэл дамжуулах сервис дуудагдана.
 - Шүүхийн шийдвэрээр өр төлбөргүй үед ямар нэгэн мэдээлэл харагдахгүй.
 - Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.

The screenshot shows the official website of the Mongolian General Election Commission. The main navigation bar includes links for 'SONGUL' (Songul), 'Acsudal' (Acsudal), 'Erekhii madzalap' (Erekhii madzalap), and 'Shuyin Lavlagaa' (Shuyin Lavlagaa). The 'Shuyin Lavlagaa' section is highlighted. On the left sidebar, there are links for 'Sekul' (Sekul) and 'Acsudal'. The main content area displays a large blue user icon placeholder. Below the icon, there is a button labeled 'ХҮР-с madzalap duudach' (ХҮР-с мэдээлэл дуудах) and a note: 'УИХ-н сонгуулд өр дэвшиж байсан тохиолдолд улсын дээд шүүхийн лавлагааг шаардлагатай бичиг баримт хавсаргах цэсээр заавал хавсаргана.' (In the election of the National Great Assembly, the law stipulates that the services of the National Court shall be provided by the National Court through the National Court's electronic voting system.)

Зураг 8. Шүүхийн лавлагаа

ҮЙЛДЭЛ 6. Цагдаагийн лавлагаа

Ял эдэлж байгаа эсэх лавлагааг “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”-ын маягтаар, авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх лавлагааг албан бичгээр тус тус олгоно.

- ХҮР-с мэдээлэл дуудах** товч дарснаар
 - Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай,
 - Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай сервис дуудагдана.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бол / Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай мэдээлэл ирсэнгүй. Хүний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай мэдээлэл ирсэнгүй. / мессеж өгнө.

The screenshot shows the official website of the Mongolian General Election Commission. The main navigation bar includes links for 'SONGUL' (Songul), 'Acsudal' (Acsudal), 'Erekhii madzalap' (Erekhii madzalap), and 'Tsagdaagiin Lavlagaa' (Tsagdaagiin Lavlagaa). The 'Tsagdaagiin Lavlagaa' section is highlighted. On the left sidebar, there are links for 'Sekul' (Sekul) and 'Acsudal'. The main content area displays a large blue user icon placeholder. Below the icon, there is a button labeled 'ХҮР-с madzalap duudach' (ХҮР-с мэдээлэл дуудах).

Зураг 9. Цагдаагийн лавлагаа



ҮЙЛДЭЛ 7. Татварын лавлагаа

Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх татварын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын тодорхойлолт.

- ХҮР-с мэдээлэл дуудах товч дээр дарснаар
 - 1.Иргэний нэр дээр татварын өр шалгах,
 - 2.Иргэний регистрийн дугаараар хувьцаа эзэмшигчийн хувь харах,
 - 3.Байгууллагын нэр дээр өртэй эсэх сервис дуудагдана.
- Хадгалах товч даран мэдээллийг хадгалж дараагийн мэдээллийг бүртгэнэ.
- Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй бол / Нэр дэвшигчийн нэр дээр татварын өр байхгүй, Нэр дэвшигчийн хувь эзэмшдэг татварын өртэй хуулийн этгээд байхгүй / мессеж өгнө.

Зураг 10. Татварын лавлагаа

ҮЙЛДЭЛ 8. Шаардлагатай бичиг баримт хавсаргах

Нэр дэвшихэд шаардлагатай баримт бичгийг Тайлбар хэсэгт баримт бичгийн нэр Файл хавсаргах хэсэгт тухайн файлыг хавсаргана.

1. Нэр дэвшигчийн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт
Сонгуулийн өрөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
2. Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл
Сонгуулийн өрөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
3. Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар
4. Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Улсын Дээд шүүхийн лавлагаа

5. Нэр дэвшигчийн намтар

Сонгуулийн ерөнхий хорооны 2020.4.07-ны өдрийн 19 дүгээр тогтооолын 3 дугаар хавсралт

6. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг /ХОМ мэдүүлсэн маягт/

The screenshot shows a user interface for document upload. On the left, there's a sidebar with a green background containing icons for home, file, and user profile. The main area has tabs for 'SONGUUL' (Sonгуул), 'Асуудал' (Asuudal), and 'Ерөнхий мэдээлэл' (Erenkhii medeel). The current tab is 'Ерөнхий мэдээлэл'. The right side shows a search bar with results for 'Шаардлагатай бичиг баримт хавсарах' (Shaaardlagatay bichig barimt havesarakh) and a file upload section. A table lists one file: 'Тайлбар' (Title) - 'Тайлбар', 'Файл хавсарах' (File to upload) - 'No file selected', and 'Файл сонгох' (File select) - 'Файл сонгох'. There's also a 'Хадгалах' (Upload) button.

Зураг 11. Шаардлагатай бичиг баримт хавсаргах цонх

3. СИСТЕМЭЭС НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

- ХҮР системээс бүх сервисийг дуудаж хадгалсан, шаардлагатай баримт бичгийг бүрэн хавсаргасан бол тухайн сонгуульд **нэр дэвших тухай хүсэлтээ системээс илгээх боломжтой**.
- Ингэхдээ өөрийн нам, эвсэл болон бие даагчийн төрлийг сонгоно.
- Мөн нэр дэвшигч өөрийн овог, нэрийн мэдээллийг саналын хуудаст хэрхэн хэвлэгдэх тухай мэдээллийг “Нэр дэвшигчийн саналын хуудаст хэвлэгдэх нэр” талбарт бөглөж оруулна.

The screenshot shows a search results page for 'Нэр дэвших мэдээлэл' (Information about voter registration). It includes a search bar with placeholder text 'Хүснэгт гарах' (Generate certificate) and 'ХҮР - ийн бүх сервисийг дуудаж хадгалсаны бараа хүснэгт гаргас боломжтой'. Below is a table with columns: №, Төлөв, Сонгууль, Нам, эвсэл, Тойрог, and Тогтоол. One row is shown: № 1, Төлөв 'Бүртгэсэн', Сонгууль 'Улсын Их Хурлын 2024 оны эзлэжт сон...', Нам, эвсэл 'Монгол Ардын Нам', Тойрог '1', Тогтоол 'Өвөрхангай аймгийн Ап'. There is also a note at the bottom: 'Саналын хуудаст хэвлэгдэх нэр: Уламсурэнгийн НАРАНХАНД - МАН'.

Зураг 12. Нэр дэвших мэдээлэл

- Тогтоол хэсэгт Нам, эвслээс нэр дэвших тогтоолоо хавсарган хүсэлт гаргах товч дээр дарснаар төлөв Хүсэлт гаргасан төлөвт шилжинэ.

The screenshot shows the same search results page as Zureg 12. The difference is that the first row in the table is highlighted in orange, indicating it is selected. The row contains the same information: № 1, Төлөв 'Хүснэгт гаргасан', Сонгууль 'Улсын Их Хурлын 2024 оны эзлэжт сон...', Нам, эвсэл 'Монгол Ардын Нам', Тойрог '1', Тогтоол 'Өвөрхангай аймгийн Араяйзээ'.

Зураг 13. Нэр дэвших мэдээлэл



Сонгуульд бүртгэх

- ⌂ X

Үндсэн мэдээлэл

* Сонгууль: Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль

Нэр дэвшигчийн төрөл: Намын жагсаалтаар нэр дэвшигч

Нам, эвсэл: МАН Монгол Ардын Нам

Нэр дэвшигч

| Кодоор | + | Бие даагч эсэх | | | | |
|--------|-----------------|----------------|-------------------|------------------|--------------------------|---------------------------------------|
| № | Эцэг (эх)-н нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Нам, эвсэл | Бие даагч эсэх | |
| 1 | Уламсүрэн | НАРАНХАНД | 1234567890 | Монгол Ардын Нам | <input type="checkbox"/> | <input type="button" value="Delete"/> |

Зураг 14. Сонгуульд бүртгэх цонх

Сонгуульд бүртгэх

- ⌂ X

Үндсэн мэдээлэл

* Сонгууль: Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль

Нэр дэвшигчийн төрөл: Тойрогт нэр дэвшигч

Бие даан нэр дэвшигч эсэх:

Тойрог: кодоор хайх нэрээр хайх

Нэр дэвшигч

| Кодоор | + |
|--------|---|
|--------|---|

Зураг 15. Бие даан нэр дэвшигч бүртгэх цонх

| | Төлөв | Тойрог |
|----|---|--------|
| 1. | <input type="checkbox"/> <input type="button" value="Бүртгэсэн"/> | 1 |
| 2. | <input type="checkbox"/> <input type="button" value="Хүсэлт гаргасан"/> | 1 |

Зураг 16. Нэр дэвшигчийн жагсаалт

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ДЭМЖИГЧИЙН БҮРТГЭЛИЙГ ЦАХИМААР ХИЙХ ЗААВАР

ҮЙЛДЭЛ 1. Дэмжигчийн бүртгэлийн жагсаалт цонхыг дуудах

- Бие даан нэр дэвшигчийн эрхээр болон Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн эрхээр Сонгуулийн мэдээллийн цахим системд нэвтэрч орно.
- Бие нэр дэвшигчийн дэмжигч бүртгэх** цэсийг дарснаар Бие даан нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонх нээгдэнэ.

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ДЭМЖИГЧИЙН ЖАГСААЛТ

Q шүүгчлүүр

+ Номж | **Засах** | **Устах**

| | Сонгууль | Нэр дэвшигч | Дэмжигч | Үүсгэсэн |
|--------------------------|------------|-------------------|---------------|----------|
| <input type="checkbox"/> | Сонгууль | Нэр дэвшигч | Дэмжигч | Үүсгэсэн |
| | Бүтгэн нэр | Регистрийн дугаар | Утасны дугаар | Огноо |
| | Гарын үсэг | Э-Мэйл хаяг | Ажилтан | |
| | | | | |

Тохигох үр дүн одсондуй

Зураг 15. Бие даан Нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонх

ҮЙЛДЭЛ 2. Дэмжигч нэмэх цонх дуудах

- Бие даан Нэр дэвшигчийн дэмжигчийн жагсаалт цонхны **Нэмэх** товч дарснаар Дэмжигч бүртгэх цонх нээгдэнэ.
- Дэмжигчийн мэдээлэл хэсэгт дэмжигчийн Регистрийн дугаарыг оруулахад дэмжигчийн мэдээлэл ХҮР-аас дуудагдана.
- Утасны дугаар хэсэгт дэмжигчийн утасны дугаарыг оруулна.
- Хавсралт файл хэсэгт гарын үсэг зурсан файлыг хавсарган Хадгалах товч дээр дарснаар жагсаалтад нэмэгдэнэ.
- Бие даан нэр дэвшигчийн “Нэр дэвшиж буй тойрог”-т Дэмжигч иргэний байнга оршин суугаа хаяг тухайн тойрогт хамаарах шаардлагатай.

Дэмжигч бүртгэх

Сонгууль: Улсын Их Хурлын 2024 оны эзлжит сонгууль

Нэр дэвшигч: НАРАНХАНД

Дэмжигчийн мэдээлэл:

Регистрийн дугаар: Регистрийн дугаараар хураас мэдээлэл дуудна

Эцэг (эх)-н нэр: Ганбаатар

Өөрийн нэр: АНХБАЯР

Утасны дугаар:

Хавсралт файл: No file selected Файл сонгох

Хадгалах | Хаах

Зураг 16. Дэмжигч бүртгэх цонх



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ДЭМЖИГЧИЙН БҮРТГЭЛ ГАР УТАСНЫ АПП БҮРТГЭХ

ҮЙЛДЭЛ 1. Дэмжигчийн бүртгэл

- Бие даан нэр дэвшигчийн эрхээр болон Нэр дэвшигчийн менежер, шадартуслагч, ухуулагчийн эрхээр E-Election аппликацьонд нэвтэрч орно.
- Дэмжигчийн бүртгэл цэсийг дарснаар **Дэмжигч бүртгэх** цонх нээгдэнэ.
- Дэмжигчийн бүртгэлийг Регистрийн дугаар болон Иргэний үнэмлэхний QR кодийг уншуулан бүртгэх боломжтой.

Зураг 18. Нүүр хуудас

Зураг 19. Дэмжигч бүртгэх

ҮЙЛДЭЛ 2.

Дэмжигчийн бүртгэл регистрийн дугаараар бүртгэхдээ:

- Дэмжигчийн регистрийн дугаарыг **регистрийн дугаар** хэсэгт оруулан ХҮР-аас дуудах товч дээр дарснаар Дэмжигчийн Овог, Нэр бүртгэгдэнэ. ХҮР-ын сервис дуудагдах үед иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл, нэр дэвшигчийн тойрот байгаа эсэхийг шалгана.
- Дэмжигчийн утасны дугаарыг бүртгэснээр утасны дугаарт **Баталгаажуулах код** илгээгдэх ба **Баталгаажуулах код** хэсэгт оруулснаар гарын үсэг зурах цонх нээгдэнэ.
- Дэмжигч гарын үсэгээ зуран **Хадгалах** товч дарснаар дэмжигчийн мэдээлэл амжилттай бүртгэгдэнэ.
 - Анхааруулга: *Иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл Нэр дэвшигчийн тойрот хамаарахгүй бол “Хаягийн шалгуур хангаагүй” мэдэгдэл гарч цааш үргэлжлүүлэх боломжгүй.*

Дэмжигчийн бүртгэл

Регистрийн дугаар
УИ9*****

Овог Нэр
Овог Нэр


Утасны дугаар
12345678

Баталгаажуулах код
12345678

Гарын үсэг зурах

Нүүр Хэсгийн хороо Статистик Нэр дэвшигч

Зураг 20. Дэмжигчийн мэдээлэл



Зураг 21. Гарын үсэг зурах

ҮЙЛДЭЛ 3.

Дэмжигчийн бүртгэл Иргэний үнэмлэхийн QR уншуулах

- Дэмжигчийн бүртгэх цонхны **QR** уншуулах товч дээр даран Иргэний үнэмлэхийн QR кодыг уншуулснаар Дэмжигчийн Овог, Нэр бүртгэгдэнэ. ХҮР-ын сервис дуудагдах үед иргэний байнга оршин суугаа хаягийн мэдээлэл, нэр дэвшигчийн тойрот байгаа эсэхийг шалгана.



- Дэмжигчийн утасны дугаарыг бүртгэнээр утасны дугаарт Баталгаажуулах код илгээгдэх ба **БАТАЛГААЖУУЛАХ КОД** хэсэгт оруулснаар гарын үсэг зурах цонх нээгдэнэ.
- Дэмжигч гарын үсэгээ зуран **Хадгалах** товч дарснаар дэмжигчийн мэдээлэл амжилттай бүртгэгдэнэ.

Зураг 22. QR уншуулах

Зураг 23. Дэмжигчийн бүртгэл

Зураг 24. Гарын үсэг зурах

- Дэмжигчийн мэдээлэл хадгалагдаж, бие даан нэр дэвшигчийн бүртгэлийн жагсаалт нэмэгдэх байдлаар 801 гарын үсгийг цуглуулах боломжтой.

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙГ ДЭМЖИКГЧИЙН ЖАГСААЛТ

Шүүлгүүр

| Сонгууль | | Иэр давшигч | | Дэмжигч | | | | Үүсгэсэн | | |
|----------|-------|-------------|--|-----------|-------------------|---------------|-------------|------------|---------|---------|
| +НЭМЭК | Засах | Устах | | Бүтэн нэр | Регистрийн дугаар | Утасны дугаар | З-Майл хаяг | Гарын үсэг | Олондоо | Ажилтан |
| | | | | | | | | | | |

Төхирх үр дүн опсончүй



Тэмдэглэл



Монгол Улсын Авлыгатай
тэмцэх газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

Тэмдэглэл



Тэмдэглэл



Тэмдэглэл
